

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2021 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ  
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ 4 ДҮГЭЭР САРЫН 20-НЫ ӨДӨР  
/МЯГМАР ГАРАГ/-ИЙН ХУРАЛДААНЫ ТОВЬЁГ**

<b>№</b>	<b>Баримтын агуулга</b>	<b>Хуудас</b>
<b>1.</b>	<b>Хуралдааны товч тэмдэглэл:</b>	1-24
<b>2.</b>	Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл	25-69
	1.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2021 оны 02 дугаар дүгнэлт	25-41
	2.Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлэг	42-45
	3.Зохиогчийн эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд	45-61
	4.Патентын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд	61-69

## Хураангуй тэмдэглэл

***Гурав.Зохиогчийн эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2020.12.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баасандорж, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга П.Сайнзориг, мөн газрын шинжээч Д.Цолмон, Оюуны өмчийн газрын Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга С.Ганзориг, мөн газрын Оюуны өмчийн хяналтын хэлтсийн дарга Д.Бат-Эрдэнэ, Аж үйлдвэрийн хэлтсийн дарга С.Урангэрэл, Монголын Оюуны өмч хамгаалах холбооны гүйцэтгэх захирал У.Тамир, Монголын Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Д.Нэргүй нар цахимаар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Баярмаа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат, референт Л.Мөнхчимэг, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн референт Б.Галсанбат нар байлцав.

Хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар ажлын хэсгийн санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг танилцуулав.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Зохиогчийн эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг зүйл бүрээр хэлэлцэв.*

Төслийн 1, 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.12-т заасны дагуу Зохиогчийн эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн талаар ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалтыг MyParliament программыг ашиглан цахим хэлбэрээр явуулав.*

**С.Бямбацогт:** 1.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.6 дахь заалтын “мэдээллийг” гэсний дараа “хуульд заасны дагуу” гэж нэмэх, мөн зүйлийн 4.1.13 дахь заалтын “энэ хуулийн 4.1.7-д заасан өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх этгээдийг /Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 4.1.5-д заасан радио, телевизийн үйлчилгээ эрхлэгчийг;” гэснийг мөн зүйлийн 4.1.27-дахь заалтын “, хиймэл дагуул” гэснийг хасаж, мөн зүйлийн 4.1.28 дахь заалтын “зохиогч, эрх эзэмшигчийн” гэснийг “зохиогч, зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрх эзэмшигчийн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 7

Б 56.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Ү

г 2.Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогтын гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.22 дахь заалтын “эзэмших” гэснийг “ашиглах” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Т Бүгд: 16

а 62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

т

г Төслийн 5, 6 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

л

з 3.Төслийн 7 дугаар зүйлийн 7.1.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн вайруулах:

а

н “7.1.2.Төрийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийн шийдвэр, албан бичиг;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 5

Бүгд: 16

68.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 7 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс санал гараагүй болно.

4.Төслийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийн “энэ хуулийн дагуу” гэснийг хасаж, мөн зүйлийн 8.1.3 дахь заалтын “нэгдэн орсон олон улсын гэрээний гишүүн улс, эсхүл Монгол Улстай уг асуудлаар хоёр талт гэрээ байгуулсан” гэснийг “олон улсын гэрээний гишүүн” гэж, 8.1.5 дахь заалтын “тус” гэснийг “Монгол” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 6

Бүгд: 16

62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 8, 9, 10, 11, 12 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

5.Төслийн 13 дугаар зүйлийн гарчгийн “Бүтээл ашиглах” гэснийг “Зохиогчийн эд хөрөнгийн” гэж өөрчилж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 13.1 дэх хэсэг нэмэх:

“13.1.Зохиогч өөрийн бүтээлийг бүхий л арга, хэлбэрээр ашиглах, эд хөрөнгийн онцгой эрх /цаашид “бүтээл ашиглах онцгой эрх” гэнэ/ эдэлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 5

Бүгд: 16

68.8 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Төслийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулж, 13.2 дахь хэсэг болгож, мөн зүйлийн 13.2 дахь хэсгийн “13.1-д” гэснийг “13.2-т” гэж өөрчлөх.

“13.2.Зохиогчийн бүтээл ашиглах онцгой эрхэд дараах эрхийг хамааруулна:” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 5

Бүгд: 16

68.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 13 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

7.Төслийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсгийг хасаж, 14.6 дахь хэсгийн “14.5-д” гэснийг “14.4-т” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 6

Бүгд: 16

62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогтын гаргасан, Төслийн 14 дүгээр зүйлийг дор дурдсанаар өөрчлөн найруулах:

“14.1.Тодорхой бүтээлийн хувьд эдлэх зохиогчийн эрхийг хамгаалах хугацааг уг бүтээлийг туурвисан, эсхүл нийтэлсэн өдрөөс эхэлж тооцно.

14.2.Зохиогчийн амины эрхийг хугацаа хязгаарлахгүй хамгаална.

14.3.Зохиогчийн бүтээл ашиглах онцгой эрх нь зохиогчийн насан туршид болон нас барснаас хойш 50 дахь жилийн 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хүчин төгөлдөр байна.

14.4.Хавсарга урлагийн бүтээлийг ашиглах онцгой эрх нь уг бүтээлийг туурвиснаас хойш 25 дахь жилийн 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хүчин төгөлдөр байна.

14.5.Зохиогч бүтээлээ зохиомол нууц нэрээр эсхүл нэргүйгээр нийтэлсэн тохиолдолд бүтээл ашиглах онцгой эрх нь бүтээлийг анх нийтэлснээс хойш 50 дахь жилийн 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хүчин төгөлдөр байна.

14.6.Энэ хуулийн 14.5-д заасан бүтээлийн зохиогч нь өөрийгөө ил болгосон эсхүл бүтээлийн зохиогч нь тодорхой болсон тохиолдолд зохиогчийн эрхийн хамгаалалтын хугацааг энэ хуулийн 14.3-т зааснаар тооцно.

14.7.Хамтын бүтээл ашиглах онцгой эрх нь зохиогчдын насан туршид болон сүүлчийн зохиогч нас барснаас хойш 50 дахь жилийн 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хүчин төгөлдөр байна.

14.8.Албан үүргийн дагуу бүтээл туурвихыг эсхүл бүтээл ашиглах онцгой эрхийг гэрээгээр хуулийн этгээдэд шилжүүлэх тохиолдолд бүтээл ашиглах онцгой эрх нь бүтээлийг анх нийтэлснээс хойш 50 дахь жилийн 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хүчин төгөлдөр байна. Хэрэв бүтээлийг туурвиснаас хойш 30 жилийн хугацаанд нийтлээгүй бол бүтээл ашиглах онцгой эрх нь бүтээл туурвиснаас хойш 50 дахь жилийн 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хүчин төгөлдөр байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 6

Бүгд: 16

62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Төслийн 15 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 15.5 дахь хэсэг нэмж, мөн зүйлийн 15.6 дахь хэсгийг 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэг болгон шилжүүлж, мөн хэсгийн “15.5-д” гэснийг “15.6-д” гэж өөрчлөх:

“15.5.Зохиогчийн бүтээл ашиглах онцгой эрхийн эрх залгамжлагч тухайн зохиогчийн бүтээлийг гуйвуулах, гажуудуулах байдлаар өөрчлөх, түүнчлэн зохиогчийн нэр төрд хохирол учруулахуйц байдлаар ашиглахыг эсэргүүцэх эрхтэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 5

Бүгд: 16

68.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 15 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан үг хэлэв.

10.Төслийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“16.1.Энэ хуулийн 13.2-т заасан эрхийг хуульд заасан болон бичгээр хийсэн гэрээний үндсэн дээр бусдад шилжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 5

Бүгд: 16

68.8 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогтын гаргасан, Төслийн 17 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 17.4 дэх хэсгийг нэмэх

“17.4.Ардын урлагийн бүтээлд тулгуурлан туурвисан үүсмэл бүтээлийн зохиогчийн эрхийг үүсмэл бүтээл туурвисан зохиогч эдэлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 5

Бүгд: 16

68.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 16, 17, 18, 19, 20 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

12.Төслийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсгийн “, эсхүл захиалагч” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 6

Бүгд: 16

62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Төслийн 22 дугаар зүйлийн 22. 4 дэх хэсгийн, 22.5 дахь хэсгийн мөн зүйлийн “тайлбарын зохиогч” гэснийг мөн зүйлийн 22.4.4 дэх заалтын “шинжлэх ухаан” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 6

Бүгд: 16

62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 21, 22, 23, 24 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

14.Төслийн 25 дугаар зүйлийн гарчгийн “зарим” гэснийг, мөн зүйлийн 25.2 дахь хэсгийг тус тус хасаж, мөн зүйлийн 25.1 дэх хэсгийн “эрхийг зохиогч, зохиогчийн” гэснийг “эрхийг энэ хуульд заасан журмын дагуу зохиогчийн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 5

Бүгд: 16

68.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 25, 26, 27 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

15.Төслийн 28 дугаар зүйлийн 28.2.2 дахь заалтын “үүнд тоглогч уран бүтээлчийн зөвшөөрлөөр түүний тоглолтын бичлэгийг өргөн нэвтрүүлэх, эсхүл нийтэд дамжуулах, тоглолтыг анх удаа шууд өргөн нэвтрүүлсэн өргөн нэвтрүүлгийн байгууллагын зөвшөөрлөөр нэгэн зэрэг дамжуулах хамаарахгүй” гэснийг хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай тайлбар нэмэх.

“Тайлбар: Энэ хуулийн 28.2.2-т заасан “дамжуулах” гэдэгт тоглогч уран бүтээлчийн зөвшөөрлөөр түүний тоглолтын бичлэгийг өргөн нэвтрүүлэх, эсхүл нийтэд дамжуулах, тоглолтыг анх шууд өргөн нэвтрүүлсэн өргөн нэвтрүүлгийн байгууллагын зөвшөөрлөөр нэгэн зэрэг дамжуулах хамаарахгүй” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 7

Бүгд: 16

56.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 28, 29, 30, 31 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

16.Төслийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсгийн “болох бөгөөд энэ хуулийн 35, 36, 37 дугаар зүйлийг баримтална” гэснийг “болно” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 6

Бүгд: 16

62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 32 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

17.Төслийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсгийн 33.2 дахь хэсгийн “Тоглогч уран бүтээлчийн” гэснийг “Хамаарах эрх эзэмшигчийн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 6

Бүгд: 16

62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 33, 34, 35, 36 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

18.Төслийн 37 дугаар зүйлийн 37.1.1 дэх хэсгийн, 37.1.2 дахь заалтын, 37.2.6 дахь заалтын, 37.3 дахь хэсгийн, 37.4 дэх хэсгийн, 37.6 дахь хэсгийн “зохиогч” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 6  
Бүгд: 16  
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 37 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

19.Төслийн 38 дугаар зүйлийн 38.2.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

“38.2.3.ашигласан хэсгийн хэмжээ нь зорилгоосоо хэтрэхгүй байх” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 6  
Бүгд: 16  
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 38, 39, 40, 41 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

20.Төслийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсгийн “зохиогчийн” гэсний дараа “эрх эзэмшигчийн” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 5  
Бүгд: 16  
68.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 42 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

21.Төслийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийн “зохиогчийн” гэсний дараа “эрх эзэмшигчийн” гэж нэмж мөн хэсгийн “нэг удаа, нэг хувийг” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 6  
Бүгд: 16  
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 43, 44 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

22.Төслийн 45 дугаар зүйлийн 45.1 дэх хэсгийн “эрхийн” гэснийг “эрх эзэмшигчийн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 6  
Бүгд: 16



62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 45 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

23.Төслийн 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсгийн “зохиогчийн” гэсний дараа “эрх эзэмшигчийн” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 7

Бүгд: 16

56.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 46 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

24.Төслийн 47 дугаар зүйлийн 47.2.2 дахь заалтын “бусад” гэсний дараа “шаардлагатай” гэж нэмэх, мөн зүйлийн 47.2.7 дахь заалтын “төлөвлөгөө (орлого, зарлага, зохион байгуулалтын бүтэц зэргийг хамааруулна).” гэснийг “төлөвлөгөөнд орлого, зарлага, зохион байгуулалтын бүтэц зэргийг хамааруулна.” гэж өөрчилж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 47.5 дахь хэсэг нэмэх:

“47.5.Энэ хуулийн 47.1.5-д заасан сургалтыг оюуны өмчийн байгууллага болон түүнээс эрх олгосон хуулийн этгээд зохион байгуулна. Сургалт зохион байгуулах журмыг оюуны өмчийн байгууллагын дарга батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 4

Бүгд: 16

75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 47 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

25.Төслийн 48 дугаар зүйлийн 48.1.1 дэх заалтыг хасаж, мөн зүйлийн 49.1.2 дахь заалтын дугаарыг “48.1.1” гэж, 48.1.3 дахь заалтын “авсан” гэснийг энэ хуулийн 48.1.1-д заасан гэж, 48.1.4 дэх заалтын “оюуны өмчийн” гэснийг “холбогдох” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 48.5.1, 48.5.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

“48.5.1.зохиогчийн эрх, хамаарах эрхийн төрөл, ангилал тус бүрд цуглуулсан төлбөрийн мэдээлэл, гишүүдэд хуваарилсан төлбөрийн дүн, захиргааны зардал болон төлөгдөөгүй бүтээл ашиглалтын төлбөрийн дүнгийн талаарх тухайн жилийн санхүүгийн мэдээлэл;

48.5.2.тухайн жилд хамтын удирдлагын байгууллагын байгуулсан лицензийн гэрээний тоо, үнийн дүн, гэрээний хэрэгжилтийн талаарх дэлгэрэнгүй тайлан;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 4

Бүгд: 16  
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 48 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

26.Төслийн 49 дүгээр зүйлийн 49.1.4 дэх заалтын “өөрчлөлтийг” гэсний дараа “эрх бүхий этгээд, гишүүдэд” гэж нэмж, мөн зүйлийн 49.5 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 5  
Бүгд: 16  
68.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 49 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

27.Төслийн 50 дугаар зүйлийн 50.3.4 дэх заалтын “даалгаврыг” гэсний дараа “хугацаанд нь” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 6  
Бүгд: 16  
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 50 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

28.Төслийн 51 дүгээр зүйлийн 51.1.1 дэх хэсгийн “баталгаажуулах” гэсний дараа “төлбөр төлөх, хуваарилахтай холбоотой гомдлыг урьдчилан шийдвэрлэх гэж, мөн зүйлийн 51.4 дэх хэсгийн “хуралдаан байна.” гэсний дараа “Зөвлөлийг нийт гишүүдийн дийлэнх олонхын ирцтэйгээр хуралдуулах бөгөөд хуралдаанд оролцсон гишүүдийн ердийн олонхын саналаар асуудлыг шийдвэрлэнэ.” гэж тус тус нэмж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 51.7, 51.8 дахь хэсэг нэмэх:

“51.7.Зөвлөлийн бүрэлдэхүүн, гомдлыг урьдчилан шийдвэрлэх, бүтээл ашиглалтын тариф батлах болон бусад үйл ажиллагаанд баримтлах журмыг оюуны өмчийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

51.8.Зөвлөлийн шийдвэрийг эс зөвшөөрвөл шийдвэрийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор гомдлоо шүүхэд гаргах эрхтэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 6  
Бүгд: 16  
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 51 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

29.Төслийн 52 дугаар зүйлийн 52.2 дахь хэсгийн “зохиогч” гэснийг хасаж, мөн зүйлийн 52.1 дэх хэсгийн “зохиогч болон эрх” гэснийг “зохиогчийн эрх болон хамаарах эрх” гэж, мөн зүйлийн 52.4 дэх хэсгийн “зохиогч” гэснийг “зохиогчийн эрх болон хамаарах” гэж, мөн зүйлийн 52.6 дахь хэсгийн “онцгой эрхийг авсан этгээд гэрээнд заасан бол” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 6  
Бүгд: 16  
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 52, 53, 54, 55, 56 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

30.Төслийн 57 дугаар зүйлийн гарчгийн, мөн зүйлийн 57.1 дэх хэсгийн “эрх болон түүнд, хамаарах” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 7  
Бүгд: 16  
56.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 57 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

31.Төслийн 58 дугаар зүйлийн гарчгийн “Шилжилтийн” гэсний дараа “үеийн” гэж нэмж, мөн зүйлийн 58.1, 58.2 дахь хэсгийг хасаж, мөн зүйлийн 58.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 58.1 дэх хэсэг болгох:

“58.1.Хамтын удирдлагын байгууллагын хувьд энэ хуулийн 49.4-т заасан хязгаарлалт 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл хамаарахгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 6  
Бүгд: 16  
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 58 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

### **Найруулгын шинжтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав**

**С.Бямбацогт:** 1.Төслийн 3 дугаар 3.2 дахь хэсгийн “асуудлыг” гэснийг “харилцааг” гэж, 4 дүгээр зүйлийн 4.1.21 дэх заалтын “хэлбэрийг” гэснийг “хуулбарыг” гэж, мөн заалтын “түүнчлэн уг” гэснийг “болгон эдгээр” гэж, мөн зүйлийн 4.1.22 дахь заалтын “хэлбэрийн” гэснийг “хуулбарын” гэж, 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалтын “байдаг” гэснийг “байрладаг” гэж, 12 дугаар зүйлийн 12.1.2 дахь заалтын “түүний” гэснийг “зохиогчийн” гэж, мөн зүйлийн 12.1.4 дэх заалтын “түүний” гэснийг “бүтээлийн” гэж, 14 дүгээр зүйлийн 14.7 дахь хэсгийн “хамгаалагдана” гэснийг “хүчин

төгөлдөр байна” гэж, 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсгийн, 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсгийн “бүтээлийг” гэснийг “бүтээл” гэж, мөн хэсгийн “зүйлийн” гэснийг “хуулийн” гэж, 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсгийн, 21.4 дэх хэсгийн “бүтээлийг” гэснийг “бүтээл” гэж, 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсгийн “энэ хуулийн” гэснийг “энэ хуульд заасны” гэж, 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсгийн “зөрчихгүй” гэснийг “зөрчихгүй байх үүрэгтэй” гэж, 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсгийн, 35 дугаар зүйлийн 35.3 дахь хэсгийн, 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсгийн, 43 дугаар зүйлийн 43.2 дахь хэсгийн “зүйлийн” гэснийг “хуулийн” гэж, мөн зүйлийн 35.4 дэх хэсгийн “олгохтой холбоотой” гэснийг “олгох” гэж, 36 дугаар зүйлийн 36.2.2 дахь заалтын “эрхүүд” гэснийг “эрх” гэж, 39 дүгээр зүйлийн 39.1.2 дахь заалтын “сонинд” гэснийг “сонин, сэтгүүлд” гэж, 41 дүгээр зүйлийн 41.6 дахь хэсгийн “ашгийн төлөө бус байгууллага эсхүл эдгээрийн” гэснийг “эрх бүхий байгууллага, эсхүл дээрх байгууллагын” гэж, 42 дугаар зүйлийн 42.1.2 дахь заалтын “үрэгдэж алга болсон” гэснийг, 42.1.3 дахь заалтын “устаж алга болсон” гэснийг “устаж, үрэгдсэн” гэж, 48 дугаар зүйлийн 48.1.5 дахь заалтын “эзэмшигчдийн” гэснийг “эзэмшигчийн” гэж, мөн заалтын “хамгаалахаар” гэснийг “хамгаалах асуудлаар” гэж, 48.1.6 дахь заалтын “орны” гэснийг “улсын” гэж, 50 дугаар зүйлийн 50.3.3 дахь заалтын “мэдээг” гэснийг “мэдээллийг” гэж, мөн зүйлийн 50.5 дахь хэсгийн “байгууллагын” гэснийг “байгууллагатай” гэж 54 дүгээр зүйлийн 54.4 дэх хэсгийн “нь” гэснийг “зохицуулалт” гэж, 55 дугаар зүйлийн 55.1 дэх хэсгийн “өв залгамжлагч байхгүй” гэснийг “өв залгамжлагчгүй” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	10
Татгалзсан:	6
Бүгд:	16

62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.19 дэх заалтын “эсхүл” гэснийг, мөн зүйлийн 4.1.29 дэх заалтын “талаарх” гэснийг, 6 дугаар зүйлийн 6.1.8 дахь заалтын “бусад” гэснийг, 7 дугаар зүйлийн 7.1.6 дахь заалтын “болсон” гэснийг, 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсгийн “хувьд” гэснийг, 14 дүгээр зүйлийн 14.6 дахь хэсгийн “болох нь” гэснийг, 21 дүгээр зүйлийн 21.4 дэх хэсгийн “энэ” гэснийг, 39 дүгээр зүйлийн 39.1.4 дэх заалтын “болсон” гэснийг, 41 дүгээр зүйлийн 41.6 дахь хэсгийн “тэдэнд” гэснийг, 47 дугаар зүйлийн 47.1.2 дахь заалтын “зөвхөн” гэснийг, 47.1.5 дахь заалтын “холбогдох” гэснийг, 54 дүгээр зүйлийн гарчгийн, мөн зүйлийн 54.1 дэх хэсгийн, 54.2 дахь хэсгийн “талаарх” гэснийг, 56 дугаар зүйлийн 56.1.6 дахь заалтын “энэ” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

3	
ө	Татгалзсан: 6
в	Бүгд: 16
ш	62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

ө 3.Төслийн 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалтын “эрхийн” гэсний дараа “тухай” гэж, 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсгийн “, эсхүл” гэсний дараа “зохиогчийн” гэж, 38 дугаар зүйлийн 38.1 дэх хэсгийн “эзэмшигчийн” гэсний дараа “эрх”, гэж, 49 дүгээр зүйлийн 49.1.3 дахь заалтын “эрх болон” гэсний дараа “хамаарах” гэж, 53 дугаар зүйлийн 53.1 дэх хэсгийн “зохиогчийн” гэсний дараа “эрх” гэж, 51 дүгээр зүйлийн 51.1 дэх хэсгийн, 57 дугаар зүйлийн гарчгийн “эрхийн” гэсний дараа “тухай” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 6  
Бүгд: 16  
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Зохиогчийн эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Зохиогчийн эрхийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.*

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс санал гараагүй болно.

Хуулийн төслийн зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.*

Төслийн 1, 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Хуулийн төслийн зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Оюуны өмчийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.*

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.12-т заасны дагуу Оюуны өмчийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалтыг MyParliament программыг ашиглан цахим хэлбэрээр явуулав.*

**С.Бямбацогт:** 1.Төслийн гарчгийн “нэмэлт” гэсний дараа өөрчлөлт гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 5  
Бүгд: 16  
68.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн “бүртгэл хийх” гэснийг “сайн дурын бүртгэл хөтлөх” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 6

Бүгд: 16  
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

3.Төсөлд доор дурдсан агуулгатай 2 дугаар зүйл нэмэх:

**“2 дугаар зүйл.** Оюуны өмчийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6 дахь хэсгийн, 24 дүгээр зүйлийн 24.2.1 дэх заалтын “эрх болон түүнд хамаарах” гэснийг хассугай.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 5  
Бүгд: 16  
68.8 хувийн саналаар дэмжигдлээ.

4.“Төслийн 2 дугаар зүйл” гэснийг “3 дугаар зүйл” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 7  
Бүгд: 16  
56.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийн зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 12 цаг 33 минутад хэлэлцэж дуусав.*

## Дэлгэрэнгүй тэмдэглэл

**За дараагийн асуудалд оръё. Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, анхны хэлэлцүүлэг явуулъя.** За Байнгын хороонд ажлын хэсгийн ахлагч Мөнхцэцэг гишүүн танилцуулгыг хийнэ.

**Ц.Мөнхцэцэг:** Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2020 оны 12 дугаар сарын 1-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Зохиогчийн эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурал 2021 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж анхны хэлэлцүүлэгт хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Хууль зүйн байнгын хорооны 2021 оны 3 дугаар сарын 03 дугаар тогтоолоор дээрх хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулж, ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг ажлын хэсгийн гишүүдэд улсын их хурлын гишүүн Б. Пүрэвдорж, Ц.Сандаг-Очир, Д.Цогтбаатар, Б.Энх-Амгалан нар болон мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх ажлын дэд хэсгийн бүрэлдэхүүнд холбогдох байгууллагын албан тушаалтнууд ажиллалаа.

Ажлын хэсэг Хууль зүй, дотоод хэргийн яамтай хамтран Зохиогчийн эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаарх нээлттэй цахим хэлэлцүүлгийг 2021 оны 4 дүгээр сарын 7-ны өдөр зохион байгуулсан бөгөөд хэлэлцүүлэгт Монголын кино уран бүтээлийг хамгаалах холбоо, Монголын зохиолч, хөгжмийн зохиолч, нийтлэлчдийн нийгэмлэг, Монголын дуу бичлэг бүтээгчдийн үндэсний төв, Монголын оюуны өмч хамгаалах холбоо, Монголын урчуудын эвлэлийн хороо, Монголын номын сангуудын, консорциум зэрэг салбар байгууллагуудын төлөөлөл болон эрдэмтэн, судлаачид оролцож хуулийн төсөлтэй холбоотойгоор тус бүр мэдээлэл хийж хуулийн төсөлд тусгах шаардлагатай зохицуулалтын талаар саналаа хэлсэн.

Ажлын хэсэг 2021 оны 4 дүгээр сарын 5, 13-ны өдрүүдэд хуралдаж хуулийн төсөлтэй холбогдуулан гарсан саналуудыг хэлэлцсэн бөгөөд мөн хэлэлцүүлгийн үеэр эрдэмтэн судлаач, салбарын төлөөллөөс ирүүлсэн 20 гаруй саналыг нэг бүрчлэн хэлэлцэж дараах санал, дүгнэлтийг байнгын хороонд танилцуулж байна.

Үүнд Зохиогч өөрийн бүтээлийг бүхий л арга хэлбэрээр ашиглах, эд хөрөнгийн онцгой эрх эдлэх эрхтэй байх, зохиогчийн бүтээл ашиглах онцгой эрх нь эрх залгамжлагч тухайн зохиогчийн бүтээлийг гуйвуулах, гажуудуулах байдлаар өөрчлөх, түүнчлэн зохиогчийн нэр төрд хохирол учруулахуйц байдлаар ашиглахыг эсэргүүцэх эрхтэй байх, гэрэл зургийн уран бүтээлийг ашиглах онцгой эрх нь уг бүтээлийг туурвисан өдрөөс эхлэн 50 жилийн хугацаанд хүчин төгөлдөр байх, бүтээлийн зүй ёсны ашиглалтыг зөрчихгүйгээр, зохиогчийн эрх эзэмшигчийн хууль ёсны ашиг сонирхлыг хөндөхгүйгээр ашигласан бүтээлийн ашигласан хэсгийн хэмжээ нь зорилгоосоо хэтрэхгүй байх, Зохиогчийн эрхийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр оюуны өмчийн байгууллагад зөвлөх бүтээл, ашиглалтын тарифыг хянан баталгаажуулах, төлбөр төлөх, хуваарилахтай холбоотой гомдлыг урьдчилан шийдвэрлэх чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөл байх. Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр хуралдаан байх бөгөөд зөвлөлийн нийт гишүүдийн дийлэнх олонхын ирцтэйгээр хуралдуулах, хуралдаанд оролцсон гишүүдийн ердийн олонхын саналаар асуудлыг шийдвэрлэх, зөвлөлийн бүрэлдэхүүн гомдлыг урьдчилан шийдвэрлэх, бүтээл, ашиглалтын тариф батлах болон бусад үйл ажиллагаанд баримтлах журмыг Оюуны өмчийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлах, зөвлөлийн шийдвэрийг эс зөвшөөрвөл шийдвэрийг хүлээн авснаас хойш гуч хоногийн дотор гомдлоо шүүхэд гаргах эрхтэй байх, 1993 оны есдүгээр сарын нэгний өдрөөс туурвисан болон хамгаалалтын хугацаа нь дуусаагүй бүтээлийн зохиогчийн эрх, тоглолт, дуу авиа бүхий дүрс бичлэг, буулгаснаас бусад панограмм өргөн нэвтрүүлгийн хамаарах эрхийг энэ хуулийн дагуу хамгаалах болон зохиогчийн эрхийн бүтээл, хамаарах эрхийн объектын ашиглалтай холбоотой үүссэн харилцаанд энэ хуулийг буцаан хэрэглэхгүй байх зохицуулалт нь холбогдох хууль тогтоомжоор төрийн өмчийн харилцааны асуудал байх тул төслөөс хасах, төслийн нэр томьёог, төслийн зүйл, хэсэг, заалт, хором болон холбогдох бусад хуулийн нэр томьёотой нийцүүлэх, хууль хоорондын уялдааг хангах зэрэг асуудлыг төсөлд с тусгах саналыг гаргасан болно.

Ажлын хэсэг хуулийн төсөл, холбогдох төсөл болон холбогдох бусад хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй 28, найрлагын шинжтэй 3 дагасан хуулийн төслийн талаарх 4 саналыг бэлтгэн томьёолж та бүхэнд тараасан байгаа.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ, дээрх хуулийн төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн санал дүгнэлт болон зарчмын



зөрүүтэй саналын томьёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

**С.Бямбацогт:** За ажлын хэсэг түрүүн танилцуулсан ажлын хэсгээрээ байгаа. За Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-т “Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ” гэж заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье.

За зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. За санал хураалт явуулъя. За ажлын хэсэг тухайн зүйл дээр санал гаргаагүй, санал хураалт байхгүй. Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүдээс бичгээр гарсан санал алга байна. За 1 дүгээр зүйлийг хэлэлцэж дууслаа.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү, алга байна. Санал хураалт, ажлын хэсэг тухайн зүйл дээр санал гаргаагүй байна. Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүдийн бичгээр гаргасан саналаар санал хураалт явуулъя санал 2 дугаар зүйл дээр байхгүй байна. За санал хураалт байхгүй. Энэ хоёрдугаар зүйл хэлж дууслаа.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. За ажлын хэсгээс тухайн зүйл дээр санал гаргаагүй. Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй. За энэ асуудлыг гуравдугаар зүйлийг хэлэлцэж дууслаа.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна. За ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулна. Нэг санал байгаа юм байна.

Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.6 дахь заалтын “мэдээллийг” гэсний дараа “хуульд заасны дагуу” гэж нэмэх, мөн зүйлийн 4.1.13 дахь заалтын “энэ хуулийн 4.1.7-д заасан өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх этгээдийг /Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 4.1.5-д заасан радио, телевизийн үйлчилгээ эрхлэгчийг/,” гэснийг мөн зүйлийн 4.1.27-дахь заалтын “, хиймэл дагуул” гэснийг хасаж, мөн зүйлийн 4.1.28 дахь заалтын “зохиогч, эрх эзэмшигчийн” гэснийг “зохиогч, зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрх эзэмшигчийн” гэж өөрчлөх гэсэн санал хураалт явуулъя. Тестийн санал хураалт гишүүд анхааралтай байгаарай. Амарсайхан гишүүн, Дэлгэрсайхан гишүүн, Нямбаатар гишүүн, Раднаасэд, Сүхбаатар гишүүд анхааралтай байна уу? За санал хураалт 1 дэх заалт сая томьёоллыг уншиж танилцуулсан дэмжье гэсэн санал хураалт явуулъя. Санал хураалтад 16 гишүүн оролцсоноос 9 гишүүн буюу 56.2 хувийн саналаар санал дэмжигдлээ. За ажлын хэсгээс гарсан санал дууссан. Гишүүдээс бичгээр гарсан нэг санал байна.

Бямбацогт гишүүн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.22 дахь заалтын “эзэмших” гэснийг “ашиглах” гэж өөрчлөх санал гаргасан Бямбацогт дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. За санал хураалтад 16 гишүүн оролцож 10 гишүүн буюу 62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. Гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна. 5 дугаар зүйлийг хэлж дууслаа.

Хуулийн төслийн 6 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна. Ажлын хэсгээс тухайн зүйл дээр санал гаргаагүй байна. Гишүүдээс санал гараагүй байна. 6 дугаар зүйлийг хэлж дууслаа.

Хуулийн төслийн 7 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. Санал хураалт явуулъя зарчмын зөрүүтэй нэг санал байгаа. Төслийн 7 дугаар зүйлийн 7.1.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.1.2.Төрийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийн шийдвэр, албан бичиг;” дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 16 гишүүн оролцсоноос 11 гишүүн буюу 68.8 хувийн саналаар санал дэмжигдлээ. За гишүүдээс бичгээр гарсан санал байхгүй байна. 7 дугаар зүйлийг хэлэлцэж дууслаа.

Хуулийн төслийн 8 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. 8 дугаар зүйл дээр 1 санал байгаа. Ажлын хэсэг гаргасан Төслийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийн “энэ хуулийн дагуу” гэснийг хасаж, мөн зүйлийн 8.1.3 дахь заалтын “нэгдэн орсон олон улсын гэрээний гишүүн улс, эсхүл Монгол Улстай уг асуудлаар хоёр талт гэрээ байгуулсан” гэснийг “олон улсын гэрээний гишүүн” гэж, 8.1.5 дахь заалтын “тус” гэснийг “Монгол” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. За 62.5 хувийн саналаар санал дэмжигдлээ. За гишүүдээс 8 дугаар зүйл дээр бичгээр гаргасан санал алга байна.

9 дүгээр зүйлийг хэлэлцье. Хуулийн төслийн 9 дүгээр зүйлтэй холбоотой асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна. За ажлын хэсгээс санал гараагүй байна. Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна. 9 дүгээр зүйл хэлэлцэж дууслаа.

10 дугаар зүйл. Хуулийн төслийн 10 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна. Ажлын хэсэг тухайн зүйл дээр санал гаргаагүй байна. Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна. 10 дугаар зүйл хэлэлцэж дууслаа.

Хуулийн төслийн 11 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна. Ажлын хэсэг тухайн зүйл дээр санал гаргаагүй байна. Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Хуулийн төслийн 12 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна. Ажлын хэсгээс тухайн зүйл дээр санал гаргаагүй байна. Гишүүд бичгээр гаргасан санал байхгүй байна. 12 дугаар зүйлийг хэлэлцэж дууслаа.

Хуулийн төслийн 13 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. За алга байна. Санал хураалт явуулна. Ажлын хэсэг 13 дугаар зүйл дээр хоёр санал байна. Төслийн 13 дугаар зүйлийн гарчгийн “Бүтээл ашиглах” гэснийг “Зохиогчийн эд хөрөнгийн” гэж өөрчилж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 13.1 дэх хэсэг нэмэх:

“13.1.Зохиогч өөрийн бүтээлийг бүхий л арга, хэлбэрээр ашиглах, эд хөрөнгийн онцгой эрх /цаашид “бүтээл ашиглах онцгой эрх” гэнэ/ эдэлнэ.” дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 16 гишүүн оролцсоноос 11 гишүүн буюу 68.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Дараагийн санал хураалт Төслийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулж, 13.2 дахь хэсэг болгож, мөн зүйлийн 13.2 дахь хэсгийн “13.1-д” гэснийг “13.2-т” гэж өөрчлөх.

“13.2.Зохиогчийн бүтээл ашиглах онцгой эрхэд дараах эрхийг хамааруулна:” санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт 68.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 14 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. За санал хураалт явуулъя. Ажлын хэсгээс бэлдсэн зарчмын зөрүүтэй 1 санал байгаа. Төслийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсгийг хасаж, 14.6 дахь хэсгийн “14.5-д” гэснийг “14.4-т” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт 62.5 хувийн саналаар дэмжигдлээ. За гишүүдээс бичгээр гаргасан 1 санал байна. Бямбацогтын гаргасан, Төслийн 14 дүгээр зүйлийг дор дурдсанаар өөрчлөн найруулах:

“14.1.Тодорхой бүтээлийн хувьд эдлэх зохиогчийн эрхийг хамгаалах хугацааг уг бүтээлийг туурвисан, эсхүл нийтэлсэн өдрөөс эхэлж тооцно.

14.2.Зохиогчийн амины эрхийг хугацаа хязгаарлахгүй хамгаална.

14.3.Зохиогчийн бүтээл ашиглах онцгой эрх нь зохиогчийн насан туршид болон нас барснаас хойш 50 дахь жилийн 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хүчин төгөлдөр байна.

14.4.Хавсарга урлагийн бүтээлийг ашиглах онцгой эрх нь уг бүтээлийг туурвиснаас хойш 25 дахь жилийн 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хүчин төгөлдөр байна.

14.5.Зохиогч бүтээлээ зохиомол нууц нэрээр эсхүл нэргүйгээр нийтэлсэн тохиолдолд бүтээл ашиглах онцгой эрх нь бүтээлийг анх нийтэлснээс хойш 50 дахь жилийн 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хүчин төгөлдөр байна.

14.6.Энэ хуулийн 14.5-д заасан бүтээлийн зохиогч нь өөрийгөө ил болгосон эсхүл бүтээлийн зохиогч нь тодорхой болсон тохиолдолд зохиогчийн эрхийн хамгаалалтын хугацааг энэ хуулийн 14.3-т зааснаар тооцно.

14.7.Хамтын бүтээл ашиглах онцгой эрх нь зохиогчдын насан туршид болон сүүлчийн зохиогч нас барснаас хойш 50 дахь жилийн 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хүчин төгөлдөр байна.

14.8.Албан үүргийн дагуу бүтээл туурвихыг эсхүл бүтээл ашиглах онцгой эрхийг гэрээгээр хуулийн этгээдэд шилжүүлэх тохиолдолд бүтээл ашиглах онцгой эрх нь бүтээлийг анх нийтэлснээс хойш 50 дахь жилийн 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хүчин төгөлдөр байна. Хэрэв бүтээлийг туурвиснаас хойш 30 жилийн хугацаанд нийтлээгүй бол бүтээл ашиглах онцгой эрх нь бүтээл туурвиснаас хойш 50 дахь жилийн 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хүчин төгөлдөр байна.” Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 16 гишүүн оролцсоноос 10 гишүүн буюу 62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 15 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Б.Энх-Амгалан гишүүн.

**Б.Энх-Амгалан:** Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Үг хэлэх гэсэн юм. Зохиогчийн эрхийн тухай хуульд дэд ажлын хэсэг яг цаас дээр сууж байгаа, боловсруулж байгаа хүмүүс нэг зүйлийг анхаараарай. Сая бол Зохиогч өөрөө зохиосон бүтээл дээрээ 25 жил гэхээд нууц нэрээр зохиосон бол 50 жил гээд зөрүүтэй юмнууд яваад байна. Хоёрдугаарт 50, 50 жилээр хаагаад байхаар тэр зохиол, бүтээлийг ард түмний хүртээл болгох, тэр зохиол, бүтээлийг жинхэнэ амилуулах оргил цаг хугацаа нь өнгөрчих вий. Уран бүтээлчид нөгөөхөөс нь сэдэвлээд кино зохиол хийх гэдэг, нэг жүжиг найруулах гэдэг, нэг шоу тоглолт хийх гэдэг, арга хэмжээ явуулах гээд нөгөөхийг нь хийх гэхээр 50 жилээр хязгаарлаад хаагдчих вий. Нэг ёсондоо ард түмнийг соён гэгээрүүлэх ажил дээр энэ хүмүүсийн ажиллах боломжийг давхар нээж өгөөрэй. Тэгэхгүй бол олигтой уран бүтээл гарахгүй шүү дээ. Нэг хүний бүтээлийн дуу, аялгуу, эсвэл нэг өгүүлбэрийг ашигласан байдаг. Миний бүтээлээс ашиглачихлаа гээд. Тэгээд ашиглахгүй болохоор найруулагч, уран бүтээл туурвиж байгаа нөхдүүд бүгдээрээ зохиолч биш шүү дээ. Зохиолын эхээс л авч ашиглана. Тэгэхээр уран бүтээл туурвих, ард түмнээ соён гэгээрүүлэх тал дээр анхаараарай гэж хэлэх гэсэн юм.

**С.Бямбацогт:** Саяны 14 дүгээр зүйл дээр бүтэн зүйл өөрчлөгдөөд санал хураагдаж байна. Энх-Амгалан гишүүний хэлж байгаа дээр бид анхаарах ёстой. Хууль зүй, дотоод хэргийн яамны ажлын хэсэг Сайнзориг дарга тодорхой тайлбар хэлээд хариулт өгөх үү.

**П.Сайнзориг:** За сайн байцгаана уу? Байнгын хорооны дарга, гишүүдийн бас асуутад тодруулж хариулт хэлье. Зөвшөөрөл манай ажлын хэсгийн гишүүдээс, яг оюуны өмчийн энэ чиглэлээр ажилладаг экспертүүд бас нэмээд хэлэх бололцоог бас хурал даргалагч зөвшөөрөл олгоно уу.

Сая хугацаануудын асуудлыг ерөнхийдөө тоогоор хугацааны үед тодруулчихад оруулж байгаа. Тэрнээс биш одоо үндсэн зарчим бас хэвээрээ. Тодорхой хэмжээнд мэдээж энэ оюуны өмчийн эрхийн хамгаалал үйлчилж байж энэнээсээ зохиогч, бас энэ эдийн засгийн үр шимийг хүртэх бололцоо гарж байгаа. Түүнээс биш энэ хугацааны 30, 50 гэдэг асуудал нь эргээд бид нар хэлэлцүүлгийн үеэр нэлээн ярьсан. Жишээ нь гэрэл зураг авагчдын зохиол бүтээлийг 25 жил хамгаалж байгааг 50 жил болгож өөрчилж байгаа гэх зэрэг өөрчлөлтүүд. Энэ өөрчлөлтүүд нь эргээд Олон улсын гэрээ конвенцтой нийцүүлж байгаа. Гол асуудал дээр маргаан гараад ирсэн учраас тийм найруулгын саналууд бол орж байгаа юм. За энэ дээр зөвшөөрвөл Нэргүй хуульч тодорхой хариулна.

**С.Бямбацогт:** Ажлын хэсгийн гишүүн Нэргүй нэмэлт хариулт өгье.

**Д.Нэргүй:** За сайн байцгаана уу. За энэ дээр болохоор хугацаа нь яг нөгөө зохиогч тэр бүтээлээсээ бүтээлдээ бусдад этгээд ашигласан тохиолдолд зөвшөөрөл өгөх болон төлбөр авахтай, өгөхтэй холбоотой харилцаа эдгээр өдөр хугацаагаар хязгаарлагдана. Тэгээд хэрвээ хугацаа нь дууссан бол Энх-Амгалан гишүүний хэлж байгаа тэр тодруулга дээр болбол чөлөөтэй ашиглалт бол чөлөөтэй явна гэсэн тодруулга байгаа. Хугацаа тоолох юман дээр хамгийн гол нь нөгөө конвенцын заалтаар бүтээл туурвиснаас хойш дараа жилийн 1 сарын 1-ээс 50 дахь жилийн 12 сарын 1, 12 сарын 31-ний өдрөөр дуусгавар болно гэдэг.

Гэтэл хэрэглээн дээр болохоор хоосон орон зай үлдээд байна. Бүтээлээ 2 сарын 1-нд туурчихсан байлаа гэхэд дараа жилийн 1 сарын 1-ээс хугацаа тоолно гээд маргаан үүсээд байна гэдэг асуудлыг илүү тодорхой болгох зорилгоор бусад улс орнуудын хамгийн зөв томъёоллыг харьцуулж жишээд энэ хугацаа тоолох томъёоллыг оруулсан байгаа.

**С.Бямбацогт:** Энх-Амгалан гишүүн тодруулъя.

**Б.Энх-Амгалан:** Та хэд маань ингээд бусад улс орнуудын жишээг тодруулсан, тэгээд зохиогчийн зохиогч маань жилийн дараа бүтээлээ ашиглах болчих гээд байна гээд зохиогч талаасаа хараад байна. За яах вэ, тэр нэгэнт зохиогчийн эрхийг хамгаалж байгаа зүйл байх. Уран бүтээлч талаасаа хараач. Уран бүтээлч талаасаа наад хүмүүс чинь жишээлбэл нэрээ нууцлаад бичсэн хүн 50 жилийн дараа гэж байгаа юм. За тэгээд нэрээ нууцалсан хэрнээ зохиол бүтээлдээ хэвлээгүй байвал бас 50 жилийн дараа гэж байгаа юм. Гэтэл 50 жилийн дараа чи наад зохиолын чинь утга агуулга, тэгээд нийгэмд хүртээх, нийгмийн сэтгэл зүй энэ тэр чинь өөр болчихно шүү дээ. Тэрний наана жинхэнэ оргил үедээ тухайн нийгмийнхээ сэтгэл зүйг гаргасан тэр бүтээлийг нь уран бүтээл болгож ард түмэндээ хүргэх тэр боломжийг нь та бүхэн хараач гэдэг л юм хэлээд байгаа юм. Энүүгээр чинь ингээд хаачих юм болбол бүгд мөнгө нэхээд тэгээд зарим нэг нь бас нэг тийм хандивын тоглолт байх хэрэгтэй зүйлүүд бас байна шүү дээ. Үндэсний телевизээр өв соёл нэвтрүүлгээрээ байдаг юм уу, соёл эрдэнээрээ байдаг юм уу? ард түмэндээ юм үзүүлмээр байдаг гэтэл энийг чинь би зохиосон, тийм мөнгө өг гээд л баахан мөнгө нэхчихдэг, бүх юм төлбөртэй болсон.../минут дуусав./

**С.Бямбацогт:** За ажлын хэсэг хариулах уу? Хэн хариулах вэ? Гар өргөж байна уу? Сайнзориг дарга хариулъя аа.

**П.Сайнзориг:** За Энх-Амгалан гишүүний асуултад тодруулж хариулъя. Таны ярьж байгаа зүйл бас зөв. Мэдээж энэ уран бүтээлийг эдийн засгийн эргэлтэд оруулж дахин тодруулж, сайжруулж үүсмэл бүтээл хийх асуудал бол энэ хуулиар хязгаарлагдаагүй. Энэ хуулийн хүрээн дээр 50 жилийн хугацаандаа эргээд энэ уран бүтээлчийн гэдэг юм уу, зохиогчийн юмыг ашиглая гэвэл тодорхой зөвшөөрөл авах, зохиогчидтойгоо тохиролцоод төлбөр төлөх үү, үгүй юу, эсвэл үнэ төлбөргүй ашиглах уу, үгүй юу гэдгээр л талууд тохирох ёстой. Энэ хугацаа өнгөрснөөс хойш тухайн уран бүтээлийг бас чөлөөтэйгөөр ашиглах эрх нь нээгдэх ийм зохицуулалт байгаа. Тэгэхээр нөгөө талдаа хэдийгээр тэр уран бүтээлийг ингээд хаагаад ашиглахгүй гэдэг санаа биш. Энэ хийж байгаа оюуны өмчийн бүтээлээсээ тэр анхдагч уран бүтээлийг санаачилж байгаа хүн бас ашиг хүртэх энэ бололцоог нь энэ хугацаа олгож байгаа юм. Тэгэхээр энэ хугацаанд үүсмэл уран бүтээл хийе, тэрийг нь жүжиг, уран бүтээл болгож амьдруулъя гэж байгаа юм бол нэгдүгээрт зөвшөөрлөө авах ёстой. Хоёрдугаарт талууд тохиролцож төлбөр үзүүлэх үү, үгүй юу гэдгээ.../минут дуусав./

**С.Бямбацогт:** Гишүүд асуулт асууж хариулт авч дууслаа. Саяны 14 дүгээр зүйл дээр ажлын хэсэг дээр эргэж сайн нягтлаарай. Манай яамныхан хуулийн эх баригч ажлын хэсэгтэй ойрхон ажиллаарай гэдгийг хэлье. Нягтлаарай.

15 дугаар зүйл дээр гишүүд асуулт асууж хариулт авч дууслаа. Санал хураалт явуулъя. За арван тав дээр нэг санал байгаа. Төслийн 15 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 15.5 дахь хэсэг нэмж, мөн зүйлийн 15.6 дахь хэсгийг 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэг болгон шилжүүлж, мөн хэсгийн “15.5-д” гэснийг “15.6-д” гэж өөрчлөх:

“15.5.Зохиогчийн бүтээл ашиглах онцгой эрхийн эрх залгамжлагч тухайн зохиогчийн бүтээлийг гуйвуулах, гажуудуулах байдлаар өөрчлөх, түүнчлэн зохиогчийн нэр төрд хохирол учруулахуйц байдлаар ашиглахыг эсэргүүцэх эрхтэй.” Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Гишүүд бэлэн үү. За төстийн санал хураалт. Энэ чинь явдаггүй шүү. За төстийн санал хураалт. Гишүүд анхааралтай байгаарай. Одоо үндсэн санал хураалт явуулъя дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя сая томъёоллыг уншиж танилцуулсан санал хураалт. За санал хураалт 68.8 хувийн саналаар дэмжигдэж байна. Гишүүдээс бичгээр гарсан санал байхгүй. 15 дугаар зүйлийг хэлэлцэж дууслаа.

Хуулийн төслийн 16 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. За санал хураалт 1 санал байгаа. Санал хураалт ажлын хэсгээс бэлдсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя. Төслийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“16.1.Энэ хуулийн 13.2-т заасан эрхийг хуульд заасан болон бичгээр хийсэн гэрээний үндсэн дээр бусдад шилжүүлнэ.” Санал гаргасан ажлын хэсэг дэмжье гэсэн саналаар санал хураалт. 68.8 хувийн саналаар санал дэмжигдлээ. Гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй. Арван зургаа дууслаа.

Хуулийн төслийн 17 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гэж нэрсэн өгье, Аалга байна. Ажлын хэсгээс тухайн зүйл дээр санал гаргаагүй байна. Гишүүдээс гарсан 1 санал байна.

Төслийн 17 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 17.4 дэх хэсгийг нэмэх

“17.4.Ардын урлагийн бүтээлд тулгуурлан туурвисан үүсмэл бүтээлийн зохиогчийн эрхийг үүсмэл бүтээл туурвисан зохиогч эдэлнэ.” Санал гаргасан Бямбацогт дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. За санал хураалт 68.8 хувийн саналаар дэмжигдэж байна.

Хуулийн төслийн 18 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна. Ажлын хэсгээс санал гаргаагүй байна. За хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүдийн бичгээр гаргасан санал байхгүй байна.

Хуулийн төслийн 19 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна. Хуулийн төсөлтэй холбогдуулан ажлын хэсгээс санал гаргаагүй гишүүдээс бас бичгээр санал байхгүй байна. Хэлэлцэж дууслаа.

Хуулийн төслийн 20 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна. За санал ажлын хэсэг санал гараагүй гишүүдээс бичгээр авсан санал байхгүй хэлэлцлээ.

Хуулийн төслийн 21 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. Санал хураалт явуулъя ажлын хэсгээс бэлдсэн зарчмын зөрүүтэй 1 санал байна. Төслийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсгийн “, эсхүл захиалагч” гэснийг хасах дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт 62.5 хувийн саналаар дэмжигдлээ. Гишүүдээс бичгээр гарсан санал алга байна.

Хуулийн төслийн 22 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна. Ажлын хэсгээс бэлдсэн зарчмын зөрүүтэй 1 санал байгаа. Санал хураалт явуулъя. Төслийн 22 дугаар зүйлийн 22. 4 дэх хэсгийн, 22.5 дахь хэсгийн мөн зүйлийн “тайлбарын зохиогч” гэснийг мөн зүйлийн 22.4.4 дэх заалтын

“шинжлэх ухаан” гэснийг тус тус хасах санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн санал хураалт явуулъя. Санал хураалт жаран 62.5 хувийн саналаар дэмжигдлээ. За гишүүдээс бичгээр гаргасан санал алга байна.

Төслийн 23 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. Ажлын хэсэг тухайн зүйл дээр санал гаргаагүй гишүүдээс бичгээр гарсан санал байхгүй. Хэлэлцэж дууслаа.

Хуулийн төслийн 24 дөрөвдүгээр зүйлтэй холбогдуулан асуулттай гишүүд байна уу? Алга байна. Ажлын хэсгээс тухайн зүйл дээр санал гаргаагүй, хуулийн төсөлтэй холбогдон гишүүдээс бичиг гарсан санал байхгүй байна. Хэлэлцэж дууслаа.

Хуулийн төслийн 25 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. За ажлын хэсгээс бэлдсэн зарчмын зөрүүтэй 1 санал байгаа юм байна. Санал хураалт явуулъя.

Төслийн 25 дугаар зүйлийн гарчгийн “зарим” гэснийг, мөн зүйлийн 25.2 дахь хэсгийг тус тус хасаж, мөн зүйлийн 25.1 дэх хэсгийн “эрхийг зохиогч, зохиогчийн” гэснийг “эрхийг энэ хуульд заасан журмын дагуу зохиогчийн” гэж өөрчлөх санал гаргасан ажлын хэсэг дэмжье гэсэн томъёолол санал хураалт явуулъя. 68.8 хувийн саналаар санал дэмжигдлээ. Гишүүдээс бичгээр гаргасан санал алга байна. 25 хэлэлцэж дууслаа.

Хуулийн төслийн 26 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? За алга байна. Ажлын хэсгээс тухайн зүйл дээр санал гараагүй. Хуулийн төсөлтэй холбогдон гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна. 26 хэлэлцэж дууслаа.

Хуулийн төслийн 27 асуулттай гишүүд байна уу. Алга байна. Ажлын хэсгээс тухайн зүйл дээр санал гаргаагүй. Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүдээс бичгээр гаргаса санал байхгүй байна. Хэлэлцэж дууслаа.

Төслийн 28 дугаар зүйлийн 28.2.2 дахь заалтын “үүнд тоглогч уран бүтээлчийн зөвшөөрлөөр түүний тоглолтын бичлэгийг өргөн нэвтрүүлэх, эсхүл нийтэд дамжуулах, тоглолтыг анх удаа шууд өргөн нэвтрүүлсэн өргөн нэвтрүүлгийн байгууллагын зөвшөөрлөөр нэгэн зэрэг дамжуулах хамаарахгүй” гэснийг хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай тайлбар нэмэх.

“Тайлбар: Энэ хуулийн 28.2.2-т заасан “дамжуулах” гэдэгт тоглогч уран бүтээлчийн зөвшөөрлөөр түүний тоглолтын бичлэгийг өргөн нэвтрүүлэх, эсхүл нийтэд дамжуулах, тоглолтыг анх шууд өргөн нэвтрүүлсэн өргөн нэвтрүүлгийн байгууллагын зөвшөөрлөөр нэгэн зэрэг дамжуулах хамаарахгүй” дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Энэ зөв юм байлгүй дээ. Х за санал хураалт 56.2 хувийн саналаар дэмжигдлээ. За хуулийн төсөлтэй холбоотой гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Хуулийн төслийн 29 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. Санал хураалт. Ажлын хэсэг тухайн зүйл дээр санал гаргаагүй. Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Хуулийн төслийн 30 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсэн өгнө үү? Алга байна. Ажлын хэсэг тухайн зүйл дээр санал гаргаагүй. Хуулийн төсөлтэй холбоотой гишүүдээс бичгээр гаргасан санал алга байна.

Хуулийн төслийн 31 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна. Ажлын хэсэг тухайн зүйл дээр санал гаргаагүй байна. Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Хуулийн төслийн 32 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна. Ажлын хэсгээс бэлдсэн зарчмын зөрүүтэй нэг санал байна. Санал хураалт явуулъя.

Төслийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсгийн “болох бөгөөд энэ хуулийн 35, 36, 37 дугаар зүйлийг баримтална” гэснийг “болно” гэж өөрчлөх санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт 62.5 хувийн саналаар дэмжигдлээ. Бичгээр гишүүдээс санал байхгүй байна.

Хуулийн төслийн 33 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. Ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй бичгээр гаргасан 1 санал байгаа юм байна.

Төслийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсгийн 33.2 дахь хэсгийн “Тоглогч уран бүтээлчийн” гэснийг “Хамаарах эрх эзэмшигчийн” гэж өөрчлөх санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулна. За гишүүдээс 62.5 хувийн саналаар дэмжигдлээ. Гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Хуулийн төслийн 34 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. Ажлын хэсгээс тухайн зүйл дээр санал гараагүй. Хуулийн төсөлтэй холбогдон бичгүүдээр бичгээр санал байхгүй байна. Хэлэлцэж дууслаа.

Хуулийн төслийн 35 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна. Ажлын хэсгээс тухайн зүйл дээр санал гараагүй гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Хуулийн төслийн 36 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. Ажлын хэсэг тухайн зүйл дээр санал гаргаагүй. Гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Хуулийн төслийн 37 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. За алга байна. Ажлын хэсгээс 1 санал байгаа юм байна.

Төслийн 37 дугаар зүйлийн 37.1.1 дэх хэсгийн, 37.1.2 дахь заалтын, 37.2.6 дахь заалтын, 37.3 дахь хэсгийн, 37.4 дэх хэсгийн, 37.6 дахь хэсгийн “зохиогч” гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 62.5 хувийн саналаар санал дэмжигдлээ. Гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Хуулийн төслийн гучин наймдугаар зүйлтэй холбогдуулан асуух, асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. За ажлын хэсгээс 1 санал байгаа юм байна. Саналыг та бүхэн уншиж танилцуулъя.



Төслийн 38 дугаар зүйлийн 38.2.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

“38.2.3.ашигласан хэсгийн хэмжээ нь зорилгоосоо хэтрэхгүй байх” санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 62.5 хувийн саналаар санал дэмжигдлээ. Гишүүдээс бичгээр гаргасан санал алга байна.

За хуулийн төслийн 39 дүгээр зүйлтэй холбоотой асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? За алга байна. Ажлын хэсэг тухайн зүйл дээр санал гаргаагүй гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Хуулийн төслийн 40 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? За алга байна. Ажлын хэсгээс тухайн зүйл дээр санал гаргаагүй гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Хуулийн төслийн 41 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү, алга байна. Ажлын хэсэг тухайн зүйл дээр санал гаргаагүй гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Хуулийн төсийн 42 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна. За зарчмын зөрүүтэй 1 санал байна. 42 дээр.

Төслийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсгийн “зохиогчийн” гэсний дараа “эрх эзэмшигчийн” гэж нэмэх санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт 68.8 хувийн саналаар дэмжигдлээ. За гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Хуулийн төслийн 43 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. Ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй 1 санал бэлдсэн байна.

Төслийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийн “зохиогчийн” гэсний дараа “эрх эзэмшигчийн” гэж нэмж мөн хэсгийн “нэг удаа, нэг хувийг” гэснийг хасах санал гаргасан ажлын хэсэг. дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 62.5 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. 43 дээр гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Хуулийн төслийн 44 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? За алга байна. Ажлын хэсгээс санал гаргаагүй байна. Гишүүдээс бичгээр гарсан санал байхгүй байна.

Хуулийн төслийн 45 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна. Ажлын хэсгээс 45 дээр 1 санал байна.

Төслийн 45 дугаар зүйлийн 45.1 дэх хэсгийн “эрхийн” гэснийг “эрх эзэмшигчийн” гэж өөрчлөх санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 62.5 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. Гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Хуулийн төслийн 46 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? За алга байна. Санал хураалт явуулъя нэг санал байна.

Төслийн 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсгийн “зохиогчийн” гэсний дараа “эрх эзэмшигчийн” гэж нэмэх санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 56.2 хувийн саналаар санал дэмжигдлээ. Унах гээд байна шүү гишүүд анхааралтай байна уу? Ирц жоохон муудаж байна шүү. Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүдийн бичгээр гаргасан саналаар санал хураалт явуулъя байхгүй байна.

Хуулийн төслийн 47 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. За зарчмын зөрүүтэй 1 санал байна.

Төслийн 47 дугаар зүйлийн 47.2.2 дахь заалтын “бусад” гэсний дараа “шаардлагатай” гэж нэмэх, мөн зүйлийн 47.2.7 дахь заалтын “төлөвлөгөө (орлого, зарлага, зохион байгуулалтын бүтэц зэргийг хамааруулна).” гэснийг “төлөвлөгөөнд орлого, зарлага, зохион байгуулалтын бүтэц зэргийг хамааруулна.” гэж өөрчилж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 47.5 дахь хэсэг нэмэх:

“47.5.Энэ хуулийн 47.1.5-д заасан сургалтыг оюуны өмчийн байгууллага болон түүнээс эрх олгосон хуулийн этгээд зохион байгуулна. Сургалт зохион байгуулах журмыг оюуны өмчийн байгууллагын дарга батална.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хараалт явуулъя. За гишүүд анхааралтай санал хураалтад 12 гишүүн буюу 75 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. Гишүүдээс бичгээр гаргасан санал алга байна.

Хуулийн төслийн 48 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? За алга байна. Санал хураалт явуулъя зарчмын зөрүүтэй 1 санал байна.

Төслийн 48 дугаар зүйлийн 48.1.1 дэх заалтыг хасаж, мөн зүйлийн 49.1.2 дахь заалтын дугаарыг “48.1.1” гэж, 48.1.3 дахь заалтын “авсан” гэснийг энэ хуулийн 48.1.1-д заасан гэж, 48.1.4 дэх заалтын “оюуны өмчийн” гэснийг “холбогдох” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 48.5.1, 48.5.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

“48.5.1.зохиогчийн эрх, хамаарах эрхийн төрөл, ангилал тус бүрд цуглуулсан төлбөрийн мэдээлэл, гишүүдэд хуваарилсан төлбөрийн дүн, захиргааны зардал болон төлөгдөөгүй бүтээл ашиглалтын төлбөрийн дүнгийн талаарх тухайн жилийн санхүүгийн мэдээлэл;

48.5.2.тухайн жилд хамтын удирдлагын байгууллагын байгуулсан лицензийн гэрээний тоо, үнийн дүн, гэрээний хэрэгжилтийн талаарх дэлгэрэнгүй тайлан;” санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 75 хувийн саналаар санал дэмжигдэж байна. 48-тай холбогдуулан гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Хуулийн төслийн 49 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. За алга байна. Ажлын хэсгээс бэлдсэн 1санал байна. Санал танилцуулъя.Санал хураалт.

Төслийн 49 дүгээр зүйлийн 49.1.4 дэх заалтын “өөрчлөлтийг” гэсний дараа “эрх бүхий этгээд, гишүүдэд” гэж нэмж, мөн зүйлийн 49.5 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томъёоллоор санал хараалт явуулъя. 68.8 хувийн саналаар санал дэмжигдлээ. Гишүүдээс бичгээр гаргасан санал алга байна.

Хуулийн төслийн 50 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү, алга байна. За ажлын хэсгээс нь 1 санал байгаа юм байна. Уншиж танилцуулъя.

Төслийн 50 дугаар зүйлийн 50.3.4 дэх заалтын “даалгаврыг” гэсний дараа “хугацаанд нь” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. 62.5 хувийн саналаар дэмжигдлээ. За гишүүдээс бичгээр гарсан санал алга байна.

Хуулийн төсөл нь 51 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү, алга байна. Ажлын хэсгээс 1 саналтай.

Төслийн 51 дүгээр зүйлийн 51.1.1 дэх хэсгийн “баталгаажуулах” гэсний дараа “төлбөр төлөх, хуваарилахтай холбоотой гомдлыг урьдчилан шийдвэрлэх гэж, мөн зүйлийн 51.4 дэх хэсгийн “хуралдаан байна.” гэсний дараа “Зөвлөлийг нийт гишүүдийн дийлэнх олонхын ирцтэйгээр хуралдуулах бөгөөд хуралдаанд оролцсон гишүүдийн ердийн олонхын саналаар асуудлыг шийдвэрлэнэ.” гэж тус тус нэмж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 51.7, 51.8 дахь хэсэг нэмэх:

“51.7.Зөвлөлийн бүрэлдэхүүн, гомдлыг урьдчилан шийдвэрлэх, бүтээл ашиглалтын тариф батлах болон бусад үйл ажиллагаанд баримтлах журмыг оюуны өмчийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

51.8.Зөвлөлийн шийдвэрийг эс зөвшөөрвөл шийдвэрийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор гомдлоо шүүхэд гаргах эрхтэй.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. 62.5 хувийн саналаар дэмжигдлээ. 51 дээр гишүүдээс бичгээр гаргасан санал алга байна.

Хуулийн төслийн 52 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү, алга байна. За 52-т ажлын хэсгээс 1 санал байна.

Төслийн 52 дугаар зүйлийн 52.2 дахь хэсгийн “зохиогч” гэснийг хасаж, мөн зүйлийн 52.1 дэх хэсгийн “зохиогч болон эрх” гэснийг “зохиогчийн эрх болон хамаарах эрх” гэж, мөн зүйлийн 52.4 дэх хэсгийн “зохиогч” гэснийг “зохиогчийн эрх болон хамаарах” гэж, мөн зүйлийн 52.6 дахь хэсгийн “онцгой эрхийг авсан этгээд гэрээнд заасан бол” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. 62.5 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. За гишүүдээс бичгээр гаргасан санал алга байна.

Хуулийн төслийн 53 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. 53 дугаар зүйл дээр ажлын хэсэг тухайн зүйлээр санал гаргаагүй байна. Гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Хуулийн төслийн 54 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна. Ажлын хэсэг тухайн зүйл дээр санал гаргаагүй. Хуулийн төсөлтэй холбоотой гишүүд бичгээр гаргасан санал байхгүй байна.

Хуулийн төсөл 55 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. Ажлын хэсгээс тухайн зүйл дээр санал гаргаагүй. Гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Хуулийн төслийн 56 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна. Ажлын хэсгээс тухайн зүйлдээ санал гаргаагүй гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Хуулийн төслийн 57 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна. Ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй 1 санал гаргасан байна.

Төслийн 57 дугаар зүйлийн гарчгийн, мөн зүйлийн 57.1 дэх хэсгийн “эрх болон түүнд, хамаарах” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулна. 56.2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. За гишүүдээс бичгээр гаргасан санал алга байна.

Хуулийн төслийн 58 дугаар зүйлтэй холбогдуулан асуулттай гишүүн д нэрсээ өгнө үү? Алга байна. Ажлын хэсгээс бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя.

Төслийн 58 дугаар зүйлийн гарчгийн “Шилжилтийн” гэсний дараа “үеийн” гэж нэмж, мөн зүйлийн 58.1, 58.2 дахь хэсгийг хасаж, мөн зүйлийн 58.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 58.1 дэх хэсэг болгох:

“58.1.Хамтын удирдлагын байгууллагын хувьд энэ хуулийн 49.4-т заасан хязгаарлалт 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл хамаарахгүй.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя аа. Санал хураалт гишүүдээ анхааралтай. Санал хураалтад 62.5 хувийн санал буюу 10 гишүүний саналаар дэмжигдлээ. За гишүүдээс бичгээр гаргасан санал алга байна.

За хуулийн төсөлд ажлын хэсгээс бэлтгэсэн найруулгын саналаар санал хураалт явуулъя аа. Найруулгын санал гурван санал байна.

Төслийн 3 дугаар 3.2 дахь хэсгийн “асуудлыг” гэснийг “харилцааг” гэж, 4 дүгээр зүйлийн 4.1.21 дэх заалтын “хэлбэрийг” гэснийг “хуулбарыг” гэж, мөн заалтын “түүнчлэн уг” гэснийг “болгон эдгээр” гэж, мөн зүйлийн 4.1.22 дахь заалтын “хэлбэрийн” гэснийг “хуулбарын” гэж, 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалтын “байдаг” гэснийг “байрладаг” гэж, 12 дугаар зүйлийн 12.1.2 дахь заалтын “түүний” гэснийг “зохиогчийн” гэж, мөн зүйлийн 12.1.4 дэх заалтын “түүний” гэснийг “бүтээлийн” гэж, 14 дүгээр зүйлийн 14.7 дахь хэсгийн “хамгаалагдана” гэснийг “хүчин төгөлдөр байна” гэж, 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсгийн, 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсгийн “бүтээлийг” гэснийг “бүтээл” гэж, мөн хэсгийн “зүйлийн” гэснийг “хуулийн” гэж, 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсгийн, 21.4 дэх хэсгийн “бүтээлийг” гэснийг “бүтээл” гэж, 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсгийн “энэ хуулийн” гэснийг “энэ хуульд заасны” гэж, 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсгийн “зөрчихгүй” гэснийг “зөрчихгүй байх үүрэгтэй” гэж, 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсгийн, 35 дугаар зүйлийн 35.3 дахь хэсгийн, 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсгийн, 43 дугаар зүйлийн 43.2 дахь хэсгийн “зүйлийн” гэснийг “хуулийн” гэж, мөн зүйлийн 35.4 дэх хэсгийн “олгохтой холбоотой” гэснийг “олгох” гэж, 36 дугаар зүйлийн 36.2.2 дахь заалтын “эрхүүд” гэснийг “эрх” гэж, 39 дүгээр зүйлийн 39.1.2 дахь заалтын “сонинд” гэснийг “сонин, сэтгүүлд” гэж, 41 дүгээр зүйлийн 41.6 дахь хэсгийн “ашгийн төлөө бус байгууллага эсхүл эдгээрийн” гэснийг “эрх бүхий байгууллага, эсхүл дээрх байгууллагын” гэж, 42 дугаар зүйлийн 42.1.2 дахь заалтын “үрэгдэж алга болсон” гэснийг, 42.1.3 дахь заалтын “устаж алга болсон” гэснийг “устаж, үрэгдсэн” гэж, 48 дугаар зүйлийн 48.1.5 дахь заалтын “эзэмшигчдийн” гэснийг “эзэмшигчийн” гэж, мөн заалтын “хамгаалахаар” гэснийг “хамгаалах асуудлаар” гэж, 48.1.6 дахь заалтын “орны” гэснийг “улсын” гэж, 50 дугаар зүйлийн 50.3.3 дахь заалтын “мэдээг” гэснийг “мэдээллийг” гэж, мөн зүйлийн

50.5 дахь хэсгийн “байгууллагын” гэснийг “байгууллагатай” гэж 54 дүгээр зүйлийн 54.4 дэх хэсгийн “нь” гэснийг “зохицуулалт” гэж, 55 дугаар зүйлийн 55.1 дэх хэсгийн “өв залгамжлагч байхгүй” гэснийг “өв залгамжлагчгүй” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. За санал хураалт гишүүд ээ. За санал хураалт 62.5 хувь саналаар дэмжигдэж байна.

Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.19 дэх заалтын “эсхүл” гэснийг, мөн зүйлийн 4.1.29 дэх заалтын “талаарх” гэснийг, 6 дугаар зүйлийн 6.1.8 дахь заалтын “бусад” гэснийг, 7 дугаар зүйлийн 7.1.6 дахь заалтын “болсон” гэснийг, 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсгийн “хувьд” гэснийг, 14 дүгээр зүйлийн 14.6 дахь хэсгийн “болох нь” гэснийг, 21 дүгээр зүйлийн 21.4 дэх хэсгийн “энэ” гэснийг, 39 дүгээр зүйлийн 39.1.4 дэх заалтын “болсон” гэснийг, 41 дүгээр зүйлийн 41.6 дахь хэсгийн “тэдэнд” гэснийг, 47 дугаар зүйлийн 47.1.2 дахь заалтын “зөвхөн” гэснийг, 47.1.5 дахь заалтын “холбогдох” гэснийг, 54 дүгээр зүйлийн гарчгийн, мөн зүйлийн 54.1 дэх хэсгийн, 54.2 дахь хэсгийн “талаарх” гэснийг, 56 дугаар зүйлийн 56.1.6 дахь заалтын “энэ” гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалтын “эрхийн” гэсний дараа “тухай” гэж, 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсгийн “, эсхүл” гэсний дараа “зохиогчийн” гэж, 38 дугаар зүйлийн 38.1 дэх хэсгийн “эзэмшигчийн” гэсний дараа “эрх”, гэж, 49 дүгээр зүйлийн 49.1.3 дахь заалтын “эрх болон” гэсний дараа “хамаарах” гэж, 53 дугаар зүйлийн 53.1 дэх хэсгийн “зохиогчийн” гэсний дараа “эрх” гэж, 51 дүгээр зүйлийн 51.1 дэх хэсгийн, 57 дугаар зүйлийн гарчгийн “эрхийн” гэсний дараа “тухай” гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт 62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа. Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн анхны хэлэлцүүлгийг хийж дууслаа.

За зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье ээ.

Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. За ажлын хэсгээс тухайн зүйл дээр санал гаргаагүй. Гишүүдээс бичгээр гаргасан санал алга байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. Ажлын хэсгээс тухайн зүйл дээр санал гаргаагүй. Хуулийн төсөлтэй холбогдон бичгээр гишүүдээс санал гараагүй байна.

Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Зохиогчийн эрх болон түүнд хамаарагдах эрхийн тухай хууль хүчингүй болсон тооцох тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийн шинэчлэн найруулагчтай хамт өргөн мэдүүлсэн Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье.

Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү, За алга байна. Ажлын хэсгээс тухайн зүйл дээр санал гаргаагүй гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. Ажлын хэсгээс тухайн зүйл дээр санал гаргаагүй, гишүүдээс бичгийг гаргасан санал байхгүй байна.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? За алга байна. Ажлын хэсгээс тухайн зүйл дээр санал гаргаагүй, гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна. Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зөөлөн бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Оюуны өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье.

Оюуны өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нэгдүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? За алга байна. Санал хураалт явуулъя. Ажлын хэсгээс бэлдсэн зарчмын зөрүүтэй 2 санал байна. За нэг дэх саналаар нь санал хураалт явуулъя.

Төслийн гарчгийн “нэмэлт” гэсний дараа өөрчлөлт гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулна. 4 саналтай юм байна. 68.8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Төслийн 1 дүгээр зүйлийн “бүртгэл хийх” гэснийг “сайн дурын бүртгэл хөтлөх” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 62.5 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. За гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу, алга байна. Ажлын хэсэг бэлдсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя.

Төсөлд доор дурдсан агуулгатай 2 дугаар зүйл нэмэх:

**“2 дугаар зүйл.** Оюуны өмчийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6 дахь хэсгийн, 24 дүгээр зүйлийн 24.2.1 дэх заалтын “эрх болон түүнд хамаарах” гэснийг хассугай.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 68.8 хувийн саналаар санал дэмжигдлээ. Дараагийн санал хураалт.

Төслийн 2 дугаар зүйл” гэснийг “3 дугаар зүйл” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 56.2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. Гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна. Зохиогчийн

эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Оюуны өмчийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлж дууслаа.

Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хийж дууслаа.

Хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Мөнхцэцэг танилцуулна.